

MAINMap буюу Монгол оронд шувууны томууны (H5N1) дэгдэлт бүртгэгдсэн газруудын газарзүйн мэдээллийн систем

http://www.wsc.org.mn/birdflu/ai_map.html



MAINMap-г хэрэглэх заавар

MAINMap үндсэн хоёр зорилгоор бүтээгдсэн болно. Үүнд

1. MAINMap нь Монгол оронд шувууны томуу гарсан цэгүүдийг бүртгэж, холбогдох үндсэн мэдээллүүдийг хадгалж, мал эмнэлэг, шувуу судлаачид, холбогдох яам, газрын албаны хүмүүст холбогдох мэдээллийг хүргэх.

2. MAINMap нь өндөр хурдны интернет, хүчтэй компьютер, газарзүйн мэдээллийн тусгай програм хангамж, үйлдэлийн хүнд систем шаардахгүйгээр шувууны томуу гарсан газрын тухай зарим мэдээллийг хэрэглэгч өөрөө хэмжих, тооцоолох боломжоор хангах зориулалтай болно.

MAINMap-д орсон шувууны томуу гарсан цэгүүдтэй холбоотой суурь мэдээллийг Дэлхийн амьтаны эрүүл мэндийн байгууллагын (OIE) веб сайтаас түүвэрлэн авсан болно. Эдгээр мэдээлэл нь Хөдөө аж ахуйн яамны Мал эмнэлэгийн газрын шугмаар албан ёсоор OIE-д очдог тул манай улсад шувууны томуу гарсан гэж үзэж байгаа албан ёсны бүртгэлтэй газрууд болно. Харин сэжигтэй болон OIE-ийн мэдээллийн санд очоогүй тохиолдолууд энд ороогүй болно.

MAINMap нь шувууны томуутай холбоотой ажилладаг онцгой байдлын мэргэжилтнүүд, хүн болон мал эмнэлэгийн ажилчид, шувуу судлаачид, биологчид, болон бүх шатны шийдвэр гаргагч албаны хүмүүст зориулагдсан болно. Хэдий тийм боловч бусад чиглэлийн судлаачид өөр өөрийн зорилгодоо нийцүүлэн ашиглах бүрэн бололцоотой.

MAINMap-ийг НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын санхүүжүүлэлт, ХҮБХХАБ-ын Зэрлэг амьтны эрүүл ахуй болон экологийн албаны (United Nations-FAO Wildlife Health and Ecology Unit) дэмжлэгтэйгээр Монголын Зэрлэг амьтан судлах хамгаалах төв санаачлан хийлээ.

Заавартай холбоотой асууж лавлах зүйлс байвал дараах хаягаар холбоо барина уу.

Зэрлэг амьтан судлах хамгаалах төв


Ундрам Плаза, 404 тоот

Улаанбаатар 210351

Утас: 70157886

Емэйл: info@wsc.org.mn

Вебхаяг: www.wsc.org.mn



Зураг 1. MAINMap-ийн үндсэн дэлгэц.

Зурган дээр байгаа улаан өнгийн дугираг дүрсээр шувууны томуугын H5N1 хэвшлийн халдвар гарсан газруудыг үзүүлсэн. Дэлгэцийн баруун гар талын босоо багана эсвэл газрын зурган дээрх улаан цэгэн дээр хулганаар нэг дарахад тухайн томуугын дэгдэлттэй холбоотой товч мэдээлэл тусгай жижиг дэлгэцэн дээр гарч ирнэ. Үүнээс **1. Томууны хэвшлийн төрөл, 2. Дэгдэлт гарсан огноо, 3. Аймгийн нэр, 4.**


Сумын нэр, 5. Газрын нэр, 6. Бүртгэгдсэн сэжигтэй шувууны тоо, 7. Үхсэн шувууны тоо, 8. Устгал хийсэн шувууны тоо гэсэн мэдээллүүдийг харж болно.

Дээрх товчлуурын зүүн талд байгаа 100% гэсэн товчлуураар газрын зургийн тодролтыг нэмэгдүүлж эсвэл багасгаж үзэхэд зориулсан.

Дэлгэцийн зүүн доод талд хоёр төрлийн зай болон талбай хэмжих хэрэгсэл байрлуулсан. Үүний “Measure distance” гэсэн хэрэгсэлээр шулуун болон аливаа замналын урт хэмжинэ. Харин “Measure area” гэсэн хэрэгсэлээр талбай зурж, хэмжээг гаргадаг.


Мөн дэлгэцийн зүүн доод талд зургийн масштаб хэмжээ заагч шугам, газрын зургийн төв цэгийн координацийг заасан жижиг цонх бий. Энэ цонхны баруун талд байгаа сам шиг дүрсийг дарахад дээрх замнал, талбай хэмжигч хэрэгсэл гарч ирнэ.

Дэлгэцийн зүүн дээд талд нийт зургийн үзэх масштабыг өөрчлөгч босоо гулгуур товч, дөрвөн зүгт хөдөлгөн байрлал тохируулагч товч байна. Мөн байрлал тохируулагч дөрвөн сумны дундын сумыг дарахад газрын зураг эхний масштаб байрлалдаа шууд шилжин очно.




Зураг 2. Хэмжигч хэрэгсэлүүдийг гаргах.


Дэлгэцийн баруун доод буланд байгаа GPS координат заасан цонхны баруун талд байгаа сам шиг дүрсийг дарахад замнал, талбай хэмжигч хэрэгсэл гарч ирнэ.




Зураг 3. Суурь зургийг сонгох, өөрчлөх. Үндсэн дэлгэцийн баруун дээд талд байгаа товчлуурыг доош буулган хэд хэдэн төрлийн суурь газрын зургаас сонголт хийх боломжтой. Дэлгэц дээрх мэдээллийг нийтэд нь харахад Google Terrain, тодорхой нэг газруудыг томруулан, нарийвчилж харахад Google Aerial эсвэл Google Hybrid илүү эвтэйхэн болохыг зөвлөж байна.




Зураг 4. Шувууны томуу гарсан нутгийг тодруулан харах. Тодорхой газрыг тодруулан, нарийвчлан үзэхэд Google Aerial эсвэл Google Hybrid-ийн суурь зураг илүү тохиромжтой. Эндээс ихэнх нутгийн газрын гадарга, онцлог зүйлсүүд тодорхоо харагддаг.




Зураг 5. Шувууны томууны голomtтой талбайн хэмжээг бодох. Measure area гэсэн бичгэн дээр дараад сонгон авсан газраа тойруулан цэг хатгах маягаар хил татна.




Зураг 6. Шувууны томууны голомттой талбайн хэмжээг харах. Талбайн хилийн татаж дуусахад хилийн зураас шулуун байдалтай болж Measure area гэсэн бичгийн доор сонгон авсан газрын талбайн хэмжээг км² эсвэл га-гаар бодогдон гарсан байхыг харж болно.




Зураг 7. Шувууны томуу гарсан газар хүртэлх зайг олох. Эхлээд тухайн нуур буюу сонгон авсан газрыг хамгийн ойролцоох сумын төвтэй нэг дэлгэцэн дээр харагддаг болтол зургийг томруулна.




Зураг 7. Шувууны томуу гарсан газар хүртэлх зайг олох. Дараагаар машин хүрч очдог гол замыг дэлгэц дээрх зургаас олж түүний дагуу Measure distance хэрэгсэлийг ашиглан зураас татна.




Зураг 8. Шувууны томуу гарсан газар хүртэлх зайг олох. Замналыг татаж дуусахад Measure distance гэсэн бичгийн дор замналын урт км-ээр өгөгдсөн байх ба түүнийг тэмдэглэж авна.



Зураг 9. Шувууны томуу гарсан газар хүртэлх зайг олох. Өөр нэг чухал мэдээлэл нь ойролцоох аймаг, сумын төвөөс томууны дэгдэлт гарсан цэг хүртэлх шулуун зайн урт байдаг. Үүнийг дээрхийн адлаар Measure distance хэрэгсэлийг ашиглан хэмжинэ.



Зураг 10. Шувууны томуу гарсан газар хүртэлх зайг олох. Замналыг татаж дуусахад Measure distance гэсэн бичгийн дор замналын урт км-ээр өгөгдсөн байх ба түүнийг тэмдэглэж авна.



Зураг 11. Шувууны томууны голомттой талбайн төв координаци буюу байр зүйн солбилцолыг олох. Дэлгэцийн зүүн доод буланд байх жижиг цонхонд дэлгэцийн төв координаци гардаг. Иймд шувууны томуу гарсан газраа аль болох томруулаад дэлгэцээ голуулан байрлуулана. Координацийн цэгийг компьютерийнхаа хулганы тусламжтайгаар очиж хуулж авч болно, эсвэл бичээд авч бас болно.

Дэлгэц дээрх зургийг хадгалахдаа Print screen товчыг дангаар эсвэл Ctrl+Alt+Sift+Prit Screen гэсэн товчуудыг зэрэг дарж дэлгэц дээрх зургаа клипбордруугаа хуулсаны дараа Word, Excel, Powerpoint зэрэг хэрэглээний програмууд дээрээ paste хийн оруулж засварлаж авч болно.

MAINMap ашиглан хийгдэх мэдээлэл бүхий тайлангийн загвар

Мэдээллийн төрөл	Мэдээлэл
<i>Шувууны томууны сэжиг бүхий шинж тэмдэг гарсан огноо</i>	
<i>Аймгийн нэр</i>	
<i>Сумын нэр</i>	
<i>Газрын нэр</i>	
<i>Бүртгээгдсэн сэжигтэй шувууны тоо</i>	
<i>Үхсэн шувууны тоо</i>	
<i>Устгал хийсэн шувууны тоо</i>	
<i>*Дээдэлт гарсан талбайн хамрах хүрээ (км²)</i>	
<i>*Ойролцоох суурин газар хүрч очих замын урт (км)</i>	
<i>*Ойролцоох суурин газар хүртэлх шулуун урт (км)</i>	
<i>*Газар нутгийн онцлог</i>	

***Эдгээрийг MAINMap-аас шууд олж бөглөх боломжтой**